



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А107

Улаанбаатар хот

Сэтгэцийн эмгэгээр хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах тухай

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалт, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэнд спортын сайдын хамтарсан 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/85/241 дугаар тушаалын Иргэн /Даатгуулагч/-н Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх зааврын 3.4, 5.5, 5.6 дугаар зүйлүүдэд Эрүүл мэнд, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын дэргэдэх Эмнэлэг Хөдөлмөр Магадлах Төв Комиссоос ирүүлсэн чиглэл, Дүүргүүдийн эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эмч нараас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сэтгэцийн эмгэгээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох цуцлах асуудлыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх сэтгэцийн өвчний эмнэлэг хөдөлмөр магадлах салбар комиссын хурлаар шийдвэрлэн ажиллахыг комиссын гишүүдэд даалгасугай.

2. Нийслэлийн дүүргүүдийн сэтгэцийн эмчийн хяналтанд байдаг үйлчлүүлэгчдийн Сэтгэцийн эмгэгээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгах асуудлыг дүүргүүдийн дэргэдэх эмнэлэг хөдөлмөр магадлах комиссоор шийдвэрлүүлэн ажиллахыг дүүргүүдийн сэтгэцийн эмч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/, Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, мэдээллийн технологи эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/, Сэтгэцийн эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын нарийн бичгийн дарга /О.Энхтуяа/ нарт тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л. НАСАНЦЭНГЭЛ

000020